



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн “Эм эргэлтийн сан” ОНӨААТҮГ-ын
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2023/02/НА-СТА-ОНА

Цахим хуудас:

www.dornogovi@audit.gov.mn

Дорноговь аймаг

Сайншанд сум

2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 261665, 70522734

Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 70523020

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Т.Оюунтуяа

Утас: 99048991

Цахим хаяг: oyuntuya@esanhuu.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ДОРНОГОВЬ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар байр, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2023.03.15 № 1-6/347

тантай _____-ны № _____-т

ЭМ ЭРГЭЛТИЙН САН ОНӨААТҮГ
-ЫН ДАРГА Б.ЖАМЬЯНЖАВ ТАНАА

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дорноговь аймгийн "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй алдаа, зөрчлүүд тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг, өргөн тархалттай, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, тохиолдсон байх, үнэн зөв байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Бэлэн мөнгөний 17.2 сая төгрөгийн ажил гүйлгээг баримтгүйгээр зарлагдсан.
- Дансны авлагын 100% буюу 168.6 сая төгрөг, дансны өглөгийн 45.5% буюу 174.5 сая төгрөгт тайлант хугацааны эцэст тооцоо нийлээгүй.
- Бараа материалд 0.5 сая төгрөгийн хасах дүн байгаа нь үлдэгдлийг бууруулсан.
- Сумдын эмийн сангуудын 8.3 сая төгрөгийн хангамжийн материал бодитоор оршин байхгүй, Сайншанд төв дээр бүртгэлтэй бичиг хэргийн материал 2.0 сая төгрөг, хангамжийн материал 17.0 сая төгрөг, бусад материал (шатахуун, сэлбэг) 2.7 сая төгрөг, нийт 21.7 сая төгрөгийн материалуудыг тоолоогүй, оршин буй эсэх нь тодорхой бус байна.
- Эмийн нөөцийн агуулахын тайлангийн үлдэгдэл гүйлгээ балансын үлдэгдлээс 22.6 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан байна.

Асуудлыг онцолсон хэсэг

010020003

2022 оны 6 дугаар сарын 24-ны өдрийн Дорноговь аймгийн ИТХ-аар "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ-ын хувьчлалын үндсэн чиглэл батлах тухай 07/14 дүгээр тогтоол батлагдсан бөгөөд цаашид тус байгууллагын үйл ажиллагаа, чиг үүргийг хэвийн үргэлжлүүлж, менежментийн үр дүнг харгалзан хувьчлах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд 2022-2025 онд зохион байгуулахыг аймгийн Засаг дарга, ТУЗ-ийн даргад даалгасан, мөн Аймгийн Засаг Даргын 2022 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 449 дүгээр захирамжаар "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ-ын хувьчлалыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, өнөөгийн нөхцөл байдалд дүгнэлт хийж, холбогдох хуулийн хүрээнд хувьчлах ажлыг зохион байгуулахыг даалгажээ.

Нийтдээ 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 3 удаа хуралдаж, уг ажлыг хэрхэн, үр дүнтэй зохион байгуулах талаар дүрэм журмыг судалж, "Менежментийн үр дүнг харгалзан хувьчлан авах этгээдийг сонгон шалгаруулах нийтлэг журам"-ыг жишиг болгон "Дорноговь аймгийн Эм эргэлтийн сан ОНӨААТҮГ-ын эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг менежментийн үр дүнг харгалзан хувьчлан авах этгээдийн сонгон шалгаруулалтын/тендерийн/ журам"-ын төслийг боловсруулж, үнийн доод хязгаарыг тогтоох тухай хэлэлцэж, балансын үнээр тооцох талаар тусган аймгийн Засаг Даргад танилцуулахаар бэлтгэл ажлыг хангажээ.

Эм эргэлтийн сангийн сумдын эмийн санд ажиллаж байсан ажилтнуудтай зөвшилцөн, шинээр эмийн сан байгуулах 13 төслийг Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн салбар комисст хүргүүлсэн. Тусгай зөвшөөрлийн салбар комиссоос нийт 13 эмийн санд тусгай зөвшөөрөл шинээр олгож, сумдад эмийн тасалдал үүсэхгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн. Нийт 17 салбараас 6 салбарыг татан буулгаж, 11 салбарын үйл ажиллагааг зогсоосон. Эм эргэлтийн сангийн өмчид байгаа 9 байрыг зогсоосон салбаруудын дээрх эмийн сангуудад түрээслэснээс 7 салбартай орон нутгийн өмчийг түрээслүүлэх гэрээ хийгдсэн байна. Уг гэрээнд түрээслэсэн эд хөрөнгийн үнийг тусгаагүй, хөрөнгө хүлээлгэн өгсөн гарын үсэггүй, "0" үлдэгдэлтэй болсон хөрөнгүүдийг үнэлээгүй байна.

Цаашид "Дорноговь аймгийн Эм эргэлтийн сан ОНӨААТҮГ-ын эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг менежментийн үр дүнг харгалзан хувьчлан авах этгээдийн сонгон шалгаруулалтын/тендерийн/ журам"-ыг батлуулах, урсгал зардлыг багасгах зорилгоор ТУЗ-д санал оруулж, бүтэц орон тоог шинэчлэн батлуулах, хүүхэд асрах чөлөөтэй байгаа албан хаагчдыг ажлаас чөлөөлж, тэтгэмжийг олгох, журмын дагуу хувьчлах зарыг олон нийтэд хүргэх зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөсөн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2022 онд тухайн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдсөн нягтлан бодох бүртгэлийн бодлого, журам заавар, холбогдох хууль эрх зүйн актуудын хэрэгжилтийг ханган, мөрдсөн эсэх асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Дотоод хяналт хариуцсан мэргэжилтэнгүй, дотоод хяналтын журам боловсруулаагүй, байгууллагын үйл ажиллагаанд Удирдах зөвлөл нь хяналт тавиагүй байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 311 дүгээр тогтоолын 1.3 -д "Аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-тай байна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 19 дүгээр зүйлийн 19.1-

д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно" заалтуудтай нийцэхгүй байна.

Байгууллагын санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх зааврын дагуу бэлтгээгүй байна. Нягтлан бодох бүртгэлийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-д "үнэн зөв байх," 5.1.5-д "хэмжигдэхүйц байх", 8.4-д "... бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", 20 дугаар зүйлийн Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэгт заасан, 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", энэ хуулийн 20.2.9-д "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах", Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 14-ний 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтад "Аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын Санхүү тайлангийн зорилтын 2-т "Санхүүгийн тайланг хугацаанд нь үнэн зөв гаргах үүрэг, хариуцлагыг аж ахуйн нэгжийн удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй ба тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, тасалбар болголт, ангилал, толилуулга, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Тус байгууллагын 2015 онд гаргасан Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг нь шаардлага хангахгүй, өөрийн байгууллагын нөхцөлд тохируулан шинэчлээгүй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.9-д "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг", 18.2-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Илрүүлэлтээр нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг хуульд заасан дарааллаар гүйцэтгээгүй. Мөнгөн хөрөнгө, бараа материалын анхан шатны баримт бүрдүүлэлт хангалтгүй, олгосон, зөвшөөрсөн, хүлээн авсан гарын үсгийн бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байна. НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйл "Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт"-ийн "13.4.Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", "13.5.Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.", "13.6.Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", "13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20 дугаар зүйл "Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг"-ийн "20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулсан ажил, гүйлгээг бүртгэхгүй байх."

заалтуудтай нийцээгүй, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд 168.6 сая төгрөгийн авлага, 306.8 сая төгрөгийн дансны өглөг тусгагдсан бөгөөд 208.6 сая төгрөгийн өглөгөд тооцоо нийлсэн, бусдад нь тооцоо нийлээгүй байна. НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйл "Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг"-ийн "20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" "20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" заалтуудтай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, толилуулга, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн "0" үлдэгдэлтэй хөрөнгүүдийг актлах, эсвэл үнэлүүлэх 1 зөвлөмж тайлант онд хэрэгжээгүй байна. Тайлант оны эцэст 96 нэр төрлийн 100 ширхэг 35.8 сая төгрөгийн хөрөнгө "0" үлдэгдэлтэй байна. Энэ нь тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангаагүй бөгөөд МУЕА-ын 2020 оны А/95 тоот тушаал "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйл Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох үндэслэл 4.2.1.10 "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2 1-д энэ хуулийн 17.1-д заасан эрх бүхий этгээдийн хууль ёсны шаардлагыг цаг тухайд нь бүрэн хэрэгжүүлэх" заалтуудтай нийцэхгүй байна.

Анхан шатны баримтын тулгалтаар 57 харилцагчаас 231.5 сая төгрөгийн төлбөрийн цахим баримт аваагүй байна. Энэ нь үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-н тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтууд, НӨАТ-ын тухай хуулийн 17.3.2-т "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" заалтуудтай нийцээгүй.

Эд хариуцагчийн гаргасан тайланг нягтлан бодогч сар бүр хянаж гарын үсгээр баталгаажуулаагүй, тайланг Сангийн Сайдын баталсан маягтын дагуу бараа материалын орлого, зарлага, эхний болон эцсийн үлдэгдлийн тоо ширхэг, хэмжээгээр тодорхой гаргаагүй, бараа материалын тайланд эд материалуудын нэрийг ажилтны нэрээр бүртгэж, хяналт тавих боломжгүй болгож байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.3, 20.2.6-д заасан "аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгийн орлого, зарлагын баримт болон санхүүгийн тайланд хоёрдугаар гарын үсэг зурах", "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Тус байгууллагын шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 1,128.6 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 477.5 сая төгрөгийн 23 гүйлгээ, 26.7 сая төгрөгийн 16 шийдвэрийг хугацаа хоцроосон. Мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 136.9 сая төгрөгийн орлогын 10 гүйлгээ, 311.5 сая төгрөгийн зарлагын 26 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах тухай 2.6 сая төгрөгийн 2 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. Энэ нь

төсөв, өмч, хөрөнгө, мөнгө шамшигдуулах, орлого нуун дарагдуулах, зориулалтын бус, үр ашиггүй зарцуулалт хийгдэх үр дагавартай. Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" 6.4.5 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр"; заалтуудтай нийцээгүй, толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Тайлант хугацааны санхүүгийн тайланд хийгдэж буй аудитад шаардсан материалуудыг тогтоосон цаг хугацаанд бүрэн гүйцэт гаргаж ирүүлээгүй, аудитын шалгалтын ажилд хүндрэл саад учруулсан бөгөөд энэ нь аудитын тайлан хугацаа хоцрох, хэрэглэгчид бодитой мэдээллээр хангагдаж чадахгүй байх, хууль хэрэгжихгүй байх үр дагавартай. Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйл "16.1.1.төрийн аудитын байгууллагын аудит хийхэд шаардагдах цаасан болон цахим хэлбэрийн мэдээлэл, баримт бичгээр хангах, уг мэдээлэл, баримт бичгийн үнэн зөв, бодитой, бүрэн байх шаардлагыг хариуцах; 16.1.3.төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд саад учруулах, ..., оролцохгүй байх; 16.1.4.төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг бүрэн ирүүлэх; 16.1.6.хуульд заасан бусад үүрэг." заалтуудтай нийцээгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага нь бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

2022 онд хэрэгжүүлэх 4 зорилтын хүрээнд, 25 арга хэмжээ төлөвлөснөөс гүйцэтгэлийг 70 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.01	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	25,947,437.58	26,263,903.78
1.1.02	Дансны авлага	255,400,746.19	168,615,485.13
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	-	0.00
1.1.04	Бусад авлага		
1.1.06	Бараа материал	355,138,474.07	216,333,788.65
1.1.07	Урьдчилж төлсөн зардал, тооцоо	-	
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	636,486,657.84	411,213,177.56
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.01	Үндсэн хөрөнгө	96,325,689.11	79,508,178.03
1.2.02	Биет бус хөрөнгө	4,146,212.12	2,874,575.75
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	100,471,901.23	82,382,753.78
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	736,958,559.07	493,595,931.34
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.01	Дансны өглөг	480,332,583.81	383,111,483.93
2.1.1.02	Цалингийн өглөг		
2.1.1.03	Татварын өр	25,858,870.90	32,833,915.48
2.1.1.04	НДШ-ийн өглөг	1,128,970.00	0.00
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	-	0.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	507,320,424.71	415,945,399.41
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.01	Урт хугацаат зээл	-	
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН	507,320,424.71	415,945,399.41
2.3	ЭЗДИЙН ӨМЧ		
2.3.01	Өмч -төрийн	189,682,669.33	189,682,669.33
2.3.02	-хувийн		
2.3.03	-хувьцаат		
2.3.05	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	1,770,000.00	1,770,000.00
2.3.09	Хуримтлагдсан ашиг	102,126,364.17	15,914,965.03
2.3.09.01	Тайлант үеийн ашиг	-63,940,899.14	-129,717,102.43
2.3.11	ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	229,638,134.36	77,650,531.93
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	736,958,559.07	493,595,931.34

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого /цэвэр/	2,267,882,744.40	1,205,799,999.04
2	Борлуулалтын өртөг	1,583,977,346.90	804,801,748.50
3	Нийт ашиг /алдагдал/	683,905,397.50	400,998,250.54
8	Бусад орлого	410,500.00	-
10	Орлогын дүн	410,500.00	-
9	Борлуулалт, маркетингийн зардал	465,582,909.75	383,574,371.13
10	Ерөнхий ба удирдлагын зардал	141,866,235.36	147,140,981.84
12	Бусад зардал	138,775,813.71	-
12.1	Зардлын дүн	746,224,958.82	530,715,352.97
18	Татвар төлөхийн өмнөх ашиг	-61,909,061.32	-129,717,102.43
19	Орлогын татварын зардал	2,031,837.82	-
20	Татварын дараах ашиг /алдагдал/	-63,940,899.14	-129,717,102.43
22	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	(63,940,899.14)	(129,717,102.43)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1	мөнгөн орлогын дүн (+)	2,566,209,918.54	1,434,783,292.28
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүсний орлого	2,217,506,545.54	1,277,465,357.28
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	348,283,373.00	157,317,935.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	420,000.00	0.00
1.2	Мөнгөн зарлагын дүн(-)	2,540,557,499.27	1,434,016,826.08
1.2.1	Ажиллагчдад төлсөн	469,938,895.60	333,148,745.60
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	61,471,691.10	41,708,153.10
1.2.3	Бараа материал худалдан авхад төлсөн	1,510,891,986.08	944,478,387.16
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	75,026,819.99	48,059,467.20
107		12,673,158.75	12,673,158.75
1.2.5	Түлш, шатхуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	13,163,509.00	34,502,450.42
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	209,710,133.50	32,119,622.60
1.2.9	Бусад мөнгөн зарлага	200,354,464.00	0.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	25,652,419.27	766,466.20
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн(-)	8,645,720.00	0.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	8,645,720.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн(-)	0.00	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	17,006,699.27	766,466.20
5	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,490,738.31	25,497,437.58
6	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	25,497,437.58	26,263,903.78

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	189,682,669.33	1,714,000.00	102,126,364.17	293,523,033.50
Залруулсан үлдэгдэл	189,682,669.33	1,714,000.00	102,126,364.17	293,523,033.50
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-63,940,899.14	-63,940,899.14
Бусад дэлгэрэнгүй орлого	-	56,000.00		56,000.00
2021 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	189,682,669.33	1,770,000.00	38,185,465.03	229,638,134.36
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-		(22,270,500.00)	-22,270,500.00
Залруулсан үлдэгдэл	189,682,669.33	1,770,000.00	15,914,965.03	207,367,634.36
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-		(129,717,102.43)	-129,717,102.43
2022 оны 12 сарын 31-р үлдэгдэл	189,682,669.33	1,770,000.00	(113,802,137.40)	77,650,531.93

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Орлогын ангилал	Тайлант оны		Зөрүү	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
Орлого	2,310,000,000	1,205,799,999	(1,104,200,001)	52
ББӨ	1,570,800,000	804,801,749	(765,998,251)	51
Нийт ашиг	739,200,000	400,998,251	(338,201,749)	54
Цалин	363,003,800	333,148,746	(29,855,054)	92
Урамшуулал	91,888,700	-	(91,888,700)	-
Шимтгэл	60,589,700	41,708,153	(18,881,547)	69
5 жилийн урамшуулал	10,808,200	8,409,918	(2,398,282)	78
Томилолт	5,000,000	4,464,000	(536,000)	89
Хангамжийн материал	8,000,000	7,798,770	(201,230)	97
Сэлбэг	5,000,000	9,414,700	4,414,700	188
Шатахуун	10,000,000	8,932,000	(1,068,000)	89
Түлш	12,000,000	7,140,000	(4,860,000)	60
Цахилгаан	15,000,000	8,518,522	(6,481,478)	57
Бичиг хэрэг	8,000,000	4,142,091	(3,857,909)	52
Холбоо	200,000	118,176	(81,824)	59
Интернет	6,500,000	5,113,647	(1,386,353)	79
Элэгдлийн зардал	15,000,000	19,817,511	4,817,511	132
Биет бус хөрөнгийн хорогдуулга	1,300,000	1,271,636	(28,364)	98
Халаалт, цэвэр бохир ус	20,000,000	11,201,345	(8,798,655)	56
Хог хаягдал зөөсөн	150,000	-	(150,000)	-
Байрны түрээс	20,000,000	18,416,405	(1,583,595)	92
Банкны шимтгэл	14,000,000	7,018,204	(6,981,796)	50
Үл хөдлөх хөрөнгийн татвар	1,661,000	1,890,507	229,507	114
Даатгалын зардал	300,000	-	(300,000)	-
Сумдын унааны зардал	10,000,000	6,634,181	(3,365,819)	66
Автомашин татвар	120,000	124,436	4,436	104
Газрын төлбөр	40,000	4,616	(35,384)	12
Хог хаягдлын татвар		350,000	350,000	
Аудитын төлбөр	3,300,000	3,360,000	60,000	102
Компьютер засвар үйлчилгээ	800,000	602,000	(198,000)	75
Программ шинэчлэлт	400,000		(400,000)	-
Гэрээт засвар үйлчилгээний зардал	2,000,000	2,423,774	423,774	121
Актлагдсан эмийн зардал	590,000	2,309,556	1,719,556	391
Гэрээт үзлэгийн зардал	1,000,000	980,000	(20,000)	98
Үйл ажиллагааны зардал	686,651,400	515,312,896	(171,338,504)	75
Сургалтын зардал	5,000,000	987,600	(4,012,400)	20
Ахмадын хороо	2,400,000	1,338,800	(1,061,200)	56
Ажилчдад тэтгэмж	3,409,900	3,000,000	(409,900)	88
Урсгал засварын зардал	20,000,000	1,060,470	(18,939,530)	5
Бусад зардал	30,809,900	6,386,870	(24,423,030)	21
Шинэ салбар			-	
Эд хогшил	10,000,000		(10,000,000)	-
Тоног төхөөрөмж	10,000,000	5,335,000	(4,665,000)	53
Нийт зардал	737,461,300	527,034,766	(210,426,534)	71
Ашиг, алдагдал	1,738,700	- 126,036,515	(127,775,215)	(7,249)

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 11 зөрчил¹ илэрснээс, 2.5 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 4 албан шаардлага, 1 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, 5 зөвлөмж өгсөн.

3.2 Албан шаардлага

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг хуульд заасан дарааллаар гүйцэтгээгүй. Мөнгөн хөрөнгө, бараа материалын анхан шатны баримт бүрдүүлэлт хангалтгүй, олгосон, зөвшөөрсөн, хүлээн авсан гарын үсгийн бүрдэлгүй тухайлбал: бэлэн мөнгөний 17.2 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байна.

НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйл “Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт”-ийн “13.4.Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, “13.5.Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.”, “13.6.Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, “13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, 20 дугаар зүйл “Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг”-ийн “20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажгаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;” заалтуудтай нийцээгүй, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

2. Өр, авлагатай холбоотой асуудал

Санхүүгийн тайланд 168.6 сая төгрөгийн дансны авлага, 306.8 сая төгрөгийн дансны өглөг тусгагдсан бөгөөд 208.6 сая төгрөгийн өглөгөд тооцоо нийлсэн, бусдад нь тооцоо нийлээгүй байна.

НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйл “Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг”-ийн “20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, “20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” заалтуудтай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, толилуулга, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3. Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Өмнөх оны аудитаар өгөгдсөн “0” үлдэгдэлтэй хөрөнгүүдийг актлах, эсвэл үнэлүүлэх 1 зөвлөмж тайлант онд хэрэгжээгүй байна. Тайлант оны эцэст 96 нэр төрлийн 100 ширхэг 35.8 сая төгрөгийн хөрөнгө “0” үлдэгдэлтэй байна.

Мөн тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангаагүй бөгөөд МУЕА-ын 2020 оны А/95 тоот тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйл Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох үндэслэл 4.2.1.10 “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.1-д энэ хуулийн 17.1-д заасан эрх бүхий этгээдийн хууль ёсны шаардлагыг цаг тухайд нь бүрэн хэрэгжүүлэх” заалтуудтай нийцэхгүй байна.

4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Тус байгууллагын шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 1,128.6 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 477.5 сая төгрөгийн 23 гүйлгээ, 26.7 сая төгрөгийн 16 шийдвэрийг хугацаа хоцроосон. Мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 136.9 сая төгрөгийн орлогын 10 гүйлгээ, 311.5 сая төгрөгийн зарлагын 26 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах тухай 2.6 сая төгрөгийн 2 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. Энэ нь төсөв, өмч, хөрөнгө, мөнгө шамшигдуулах, орлого нуун дарагдуулах, зориулалтын бус, үр ашиггүй зарцуулалт хийгдэх үр дагавартай.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ.” 6.4.5 “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”; заалтуудтай нийцээгүй, толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

5. Шалгагдагч байгууллагын хуулиар хүлээсэн үүрэгтэй холбоотой асуудал

Тайлант хугацааны санхүүгийн тайланд хийгдэж буй аудитад шаардсан материалуудыг тогтоосон цаг хугацаанд бүрэн гүйцэт гаргаж ирүүлээгүй, аудитын шалгалтын ажилд хүндрэл саад учруулсан бөгөөд энэ нь аудитын тайлан хугацаа хоцрох, хэрэглэгчид бодитой мэдээллээр хангагдаж чадахгүй байх, хууль хэрэгжихгүй байх үр дагавартай.

Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйл “16.1.1.төрийн аудитын байгууллагын аудит хийхэд шаардагдах цаасан болон цахим хэлбэрийн мэдээлэл, баримт бичгээр хангах, уг мэдээлэл, баримт бичгийн үнэн зөв, бодитой, бүрэн байх шаардлагыг хариуцах; 16.1.3.төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд саад учруулах, ..., оролцохгүй байх; 16.1.4.төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг бүрэн ирүүлэх; 16.1.6.хуульд заасан бусад үүрэг.” заалтуудтай нийцээгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

1. Дотоод хяналттай холбоотой

Ерөнхий нягтлан бодогчийг 2022 оны 5 дугаар сарын 24-ний өдрөөс томилохдоо шууд хяналт тавьдаг тооцооны нягтлан бодогчийн ажлыг 6-12 дугаар саруудад хавсран гүйцэтгүүлж, сарын үндсэн цалингийн 39 хувь буюу нийтдээ 2.5 сая төгрөгийг тооцож олгосон байна.

НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйл “Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг”-ийн “20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, “20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” заалтуудтай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, толилуулга, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3.3 Зөвлөмж

1. Санхүүгийн тайлан, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх зааврын дагуу бэлтгээгүй байна. Энэ нь үнэн зөв мэдээллээр хангагдахгүй байх, хууль, тогтоол шийдвэр хэрэгжихгүй байх үр дагавартай.

Нягтлан бодох бүртгэлийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-д “үнэн зөв байх;” 5.1.5-д “хэмжигдэхүйц байх”, 8.4-д “... бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна”, 20 дугаар зүйлийн Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэгт заасан, 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, энэ хуулийн 20.2.9-д “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах”, Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 14-ний 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтад “Аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын Санхүү тайлангийн зорилтын 2-т “Санхүүгийн тайланг хугацаанд нь үнэн зөв гаргах үүрэг, хариуцлагыг аж ахуйн нэгжийн удирдлага хүлээнэ” гэсэн заалтуудтай нийцэхгүй ба тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, тасалбар болголт, ангилал, толилуулга, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын тушаалыг мөрдөж хэрэгжүүлж ажиллах, батлагдсан маягтын дагуу санхүүгийн тайланг гаргах, СТОУС-ыг мөрдөх

2. Санхүүгийн бүртгэл, бодлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагын 2015 онд гаргасан Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг нь шаардлага хангахгүй, өөрийн байгууллагын нөхцөлд тохируулан шинэчлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.9-д “ Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг”, 18.2-д “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Өөрийн байгууллагын онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг боловсруулан, захирлаар батлуулж, мөрдөн ажиллах

3. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Дотоод хяналт хариуцсан мэргэжилтэнгүй, дотоод хяналтын журам боловсруулаагүй, байгууллагын үйл ажиллагаанд Удирдах зөвлөл нь хяналт тавиагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 311 дүгээр тогтоолын 1.3 -д “Аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-тай байна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 19 дүгээр зүйлийн 19.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно” заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дотоод хяналтын журам боловсруулж, хяналтын тогтолцоог зохих түвшинд зохион байгуулах. Хяналтын үйл ажиллагааг тодорхой давтамжтайгаар /сар бүр, тайлант хугацааны эцсийн байдлаар гэх мэт/ үр дүнтэй хэрэгжүүлж байх. Үнэн зөв байх, цаг хугацаандаа байх зарчмуудыг мөрдөж гарсан ажил гүйлгээг тухай бүрт нь бодитой бүртгэх.

4. Төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Анхан шатны баримтын тулгалтаар 57 харилцагчаас 231.5 сая төгрөгийн төлбөрийн цахим баримт аваагүй байна.

Энэ нь үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-н тухай хуулийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтууд, НӨАТ-ын тухай хуулийн 17.3.2-т “бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”; 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” заалтуудтай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Худалдан авалтыг тооцоо хийгдсэн тухай бүрд нь цаасан болон цахим ибаримтыг үндэслэн санхүүгийн тайланд тусгаж ажиллах.

5. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Эд хариуцагчийн гаргасан тайланг нягтлан бодогч сар бүр хянаж гарын үсгээр баталгаажуулаагүй, тайланг Сангийн Сайдын баталсан маягын дагуу бараа материалын орлого, зарлага, эхний болон эцсийн үлдэгдлийн тоо ширхэг, хэмжээгээр тодорхой гаргаагүй, бараа материалын тайланд эд материалуудын нэрийг ажилтны нэрээр бүртгэж, хяналт тавих боломжгүй болгож байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.3, 20.2.6-д заасан “аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгийн орлого, зарлагын баримт болон санхүүгийн тайланд хоёрдугаар гарын үсэг зурах”, “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодогч сар бүр эд хариуцагчийн тайланг хянан, тоо ширхэгийг тодорхой гаргаж, гарын үсэг болон бусад баталгаажуулалтыг ханган, холбогдох хууль, журам зааврыг мөрдөж ажиллах.

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтүүдийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Ерөнхий нягтлан бодогчийг 2022 оны 5 дугаар сарын 24-ний өдрөөс томилохдоо шууд хяналт тавьдаг тооцооны нягтлан бодогчийн ажлыг 6-12 дугаар саруудад хавсран гүйцэтгүүлж, сарын үндсэн цалингийн 39 хувь буюу нийтдээ 2.5 сая төгрөгийг тооцож олгосон байна.	1	2,457.0			1	2,457.0							
Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг хуульд заасан дарааллаар гүйцэтгээгүй. Мөнгөн хөрөнгө, бараа материалын анхан шатны баримт бүрдүүлэлт хангалтгүй, олгосон, зөвшөөрсөн, хүлээн авсан гарын үсгийн бүрдэлгүй тухайлбал: бэлэн мөнгөний 17.2 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байна.	1				1								
Санхүүгийн тайланд 168.6 сая төгрөгийн авлага, 306.8 сая төгрөгийн дансны өглөг тусгагдсан бөгөөд 208.6 сая төгрөгийн өглөгөд тооцоо нийлсэн, бусдад нь тооцоо нийлээгүй байна.	1				1								
Өмнөх оны аудитаар өгөгдсөн "0" үлдэгдэлтэй хөрөнгүүдийг актлах, эсвэл үнэлүүлэх 1 зөвлөмж тайлант онд хэрэгжээгүй байна. Тайлант оны эцэст 96 нэр төрлийн 100 ширхэг 35.8 сая төгрөгийн хөрөнгө "0" үлдэгдэлтэй байна.	1				1								
Анхан шатны баримтын тулгалтаар 57 харилцагчаас 231.5 сая төгрөгийн төлбөрийн цахим баримт аваагүй байна.	1						1						
Эд хариуцагчийн гаргасан тайланг нягтлан бодогч сар бүр хянаж гарын үсгээр баталгаажуулаагүй, тайланг Сангийн Сайдын баталсан маягтын дагуу бараа материалын орлого, зарлага, эхний болон эцсийн үлдэгдлийн тоо ширхэг, хэмжээгээр тодорхой гаргаагүй, бараа материалын тайланд эд материалуудын нэрийг ажилтны нэрээр бүртгэж, хяналт тавих боломжгүй болгож байна.	1						1						
Тайлант хугацааны санхүүгийн тайланд хийгдэж	1								1	2			

буй аудитад шаардсан материалуудыг тогтоосон цаг хугацаанд бүрэн гүйцэт гаргаж ирүүлээгүй, аудитын шалгалтын ажилд хүндрэл саад учруулсан.											
Дотоод хяналт хариуцсан мэргэжилтэнгүй, дотоод хяналтын журам боловсруулаагүй, байгууллагын үйл ажиллагаанд Удирдах зөвлөл нь хяналт тавиагүй байна.	1					1					
Байгууллагын санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх зааврын дагуу бэлтгээгүй байна.	1					1					
Тус байгууллагын 2015 онд гаргасан Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг нь шаардлага хангахгүй, өөрийн байгууллагын нөхцөлд тохируулан шинэчлээгүй байна.	1					1					
Нийт	10	2,457.0			4	2,457.0	5		1	2	

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Тус байгууллагын шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 1,128.6 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 477.5 сая төгрөгийн 23 гүйлгээ, 26.7 сая төгрөгийн 16 шийдвэрийг хугацаа хоцроосон. Мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 136.9 сая төгрөгийн орлогын 10 гүйлгээ, 311.5 сая төгрөгийн зарлагын 26 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах тухай 2.6 сая төгрөгийн 2 шийдвэрийг огт мэдээлээгүй байна.	1		-	-	1	-			
Дүн	1		-	-	1	-			